



● Үндэсний тэтгэврийн тогтолцоо гэж юу вэ?

- ▶ Ажиллах хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлж, өндөр настай болох, хөдөлмөрийн чадвараа алдах, нас барах тохиолдолд өөрийн болон гэр бүлийнхээ амьжиргааны тогтвортой байдлыг хангах нийгмийн хамгааллын тогтолцоо юм.

● Үндэсний тэтгэврийн хөтөлбөрт заавал хамрагдах шаардлага

- ▶ Солонгос улсад оршин суугч 18-аас дээш, 60-аас доош насны гадаадын аливаа иргэн Солонгосын иргэдийн нэгэн адил Үндэсний тэтгэврийн үйлчилгээнд албан журмаар хамрагдана. Солонгос иргэдийг өөрийн улсын ийм тогтолцоонд хамруулдаггүй улсын иргэд үүнд хамаарахгүй.
- ▶ Түүнчлэн БНСУ-тай Нийгмийн хамгааллын гэрээ байгуулсан улсын иргэнд энэ тогтолцоо үйлчлэхгүй.

● Тэтгэврийн даатгалын хураамж

- ▶ Тухайн ажилчин болон ажиллуулагч тус бүр тэрхүү ажилчны сарын орлогын (хувийн бизнесийн эрхлэгчийн хувьд бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлдвэрлэл, бусад бизнесээс олсон орлогын) 4.5 хувьтай тэнцэх /нийт 9 хувь/ хэмжээний нийгмийн даатгалын шимтгэл тус тус төлнө.
- ▶ Орон нутгийн хувьд сарын бодит орлогын 9 хувьтай тэнцэх хураамж төлнө.
※ Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хураамжийн хэмжээ нь солонгос иргэдийнхтэй нэгэн адил байх бөгөөд хураамжийг дараа сарын 10-ны дотор төлөх ёстой.

● Тэтгэвэр тэтгэмж

- ▶ Нийгмийн даатгал төлж байгаа гадаадын иргэд өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэмжийг солонгос иргэний адил хэмжээгээр авна.
- ▶ Өндөр насны тэтгэвэр
 - Арван жилээс дээш хугацаанд нийгмийн даатгал төлөөд 60 нас хүрсэн хүн сар тутам өндөр насны тэтгэвэр авна. Өндөр насны тэтгэвэр авч эхлэх насны хязгаар нь 2013 оноос 5 жил бүрээр нэг насаар хойшлож, 2013 оноос хойш 65 наснаас эхлэнэ.
- ▶ Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж
 - Нийгмийн даатгал төлөх явцдаа өвчин, ослоор хөдөлмөрийн чадвараа алдаж, эмчлүүлсэний дараа тэр байдал хэвээр үргэлжлэх аваас хөдөлмөрийн чадвар алдсан түвшингийн дагуу 1-3 дугаар зэрэглэлээр тэтгэмж авна. Дөрөвдүгээр зэрэглэл бол нэг удаагийн тэтгэлэг авна.
- ▶ Тэжээгчээ алдсаны тэтгэмж
 - Нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаад болон тэтгэвэр, тэтгэмж авч байгаад нас барсан тохиолдолд ар гэрийнхэнд нь тэжээгчээ алдсаны тэтгэмж олгоно.



▶ Шимтгэлийг буцааж олгох

- Тухайн гадаадын иргэний харьяалах улс нь БНСУ-тай Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулсан улсын иргэд, мөн БНСУ-ын иргэдэд нийгмийн хамгааллын шимтгэл буцаан олгож буй орны иргэд, Солонгост E-8, E-9, H-2 ангилалын визээр оршин сууж байсан гадаадын иргэдэд эх орондоо бүрмөсөн буцах, нас барах, 60 нас хүрэхэд нь тус улсад төлж байсан шимтгэлийг хадгаламжийн хүүгийнх нь хамт нэг удаа бөөнөөр нь буцаан олгоно.

[Шимтгэлийг буцаан олгох болон шимтгэлд үл хамаарах орнууд]

| Хэлэлцээрээр зохицуулагдах орнууд / 5 улс/ | Харилцан адил үйлчлэх орнууд /29 улс/ | Үл хамрагдах орнууд / 18 улс/ |
|--|---|--|
| Герман, АНУ, Канад, Унгар, Франц | Белги, Гренада, Нигери, Барбадос, Зимбабе, Камерун, Конго, Тайланд, Того, Венесеул, Гана, Малайз, Судан, Шриланка, Швецари, Эльсальвадор, Иордан, Энэтхэг, Индонези, Казахстан, Кения, Тренадотабако, Филиппин, Хонконг, Турк, Колумбия зэрэг | ӨАБНУ, Бирм, ОХУ , Малта, Мيانмар, Бангладеш, Вьетнам, Сауди Арав, Сингапур, Армени, Украин , Этопи, Иран, Египит, Тонга, Фижи, Пакистан, Камбож |

● Эгүүлж авах журам

- ▶ Бүрдүүлэх материал
 - Эх орондоо буцахын өмнө :
Нэхэмжлэл, гадаад паспорт, оршин суугчийн үнэмлэх, Солонгос дахь банкны дэвтрийн хуулбар, нисэх болон усан онгоцны тийэний хуулбар Нэхэмжлэл /Солонгосын нотариат, ЭСЯ-ны нотариат, гадаад паспортын хуулбар, өөрийнх нь банкны хадгаламжийн дэвтрийн хуулбар
 - Гадаадаас шуудангаар нэхэмжлэхэд :
Нэхэмжлэл /оршин суугаа орны нотариат, тэндэх Солонгосын ЭСЯ-ны нотариатаар батлуулсан/, гадаад паспортын хуулбар, өөрийн банкны дэвтрийн хуулбар
※ Солонгос дахь итгэмжлэгдсэн хүнээр дамжуулж олгохгүй.
- ▶ Материал хүлээн авах газар : Үндэсний тэтгэврийн албаны бүх салбар.
(www.nps.or.kr ⇒ Regionak Offices)